

Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.01.24

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Хятад, Энэтхэг, Япон, БНСУ, Их Британи зэрэг орнууд газрын тосны стратегийн нөөцөөсөө зах зээлд нийлүүлнэ.
- Microsoft компани видео тоглоом үйлдвэрлэгч Activision Blizzard компанийг 69 тэрбум ам.доллараар худалдан авахаа мэдэгдсэн нь АНУ-ын түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй хэлцэл болж байна.
- Лхагва гарагт АНУ-ын NASDAQ индекс 11 сард бүх цагийн үеийн түүхэн дээд ханшнаасаа 11 хувийн уналт үзүүлж цар тахлаас хойшхи 4 дэх удаагаа засварын хөдөлгөөн хийлээ.
- Netflix компани 4 дүгээр улирлын тайлангаа олон нийтэд танилцуулахад шинэ харилцагчдын тоо таамагласнаас буурах төлөвтэй байгаа нь хувьцааны ханшийг 20 хувиар унагаав.

2022 он 01 сарын 24

Dow Jones	34,265
S&P 500	4,397.94
Nasdaq	14,438.4
DAX	15,603.88
FTSE	7,494.13
S&P/ASX	7,175.8
HANG SENG	24,965.55

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Улирал	Хагас жил	Жил	5 жил
Dow Jones	-1.30%	-4.71%	-4.18%	-6.34%	-4.31%	-1.60%	10.54%	70.53%
S&P 500	-1.89%	-5.61%	-6.36%	-8.31%	-3.83%	0.70%	14.49%	91.66%
Nasdaq	-2.75%	-7.37%	-10.76%	-12.5%	-7.45%	-3.36%	8.20%	179.38%

2022 оны 01 сарын 24-ний 11:00

DJIA 34,701.69 дээр нээгдэж 34,265.37 дээр хаагдлаа. SP500 индексийн хувьд 5.61% хувь бууралттай долоо хоног өнгөрлөө.

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Улирал	Хагас жил	Жил	5 жил
DAX	-1.94%	-2.01%	0.067%	-2.60%	0.03%	0.58%	12.47%	32.08%
FTSE 100	-1.20%	-0.65%	1.64%	-0.15%	3.76%	6.64%	12.88%	4.31%

2022 оны 01 сарын 24-ний 11:00

FTSE 100 (Лондонгийн биржийн топ-100 компани) индекс 0.65 хувийн бууралттай байсан бол DAX (Франкфуртийн биржийн топ 30 компани) 2.01 хувийн бууралтыг мөн үзүүлжээ.

Азийн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Улирал	Хагас жил	Жил	5 жил
S&P/ASX 200	-2.27%	-2.98%	-2.87%	-5.45%	-3.70%	-2.96%	5.14%	25.58%
Hang Seng	0.053%	2.36%	7.64%	7.26%	-4.67%	-8.62%	-17.22%	7.94%

2022 оны 01 сарын 03-ний 11:00

S&P/ASX200 (Австралийн биржийн топ 200 компани) индекс хувь 2.98 хувь буурсан бол Hang Seng (ХонКонгийн биржийн индекс) 2.36 хувь өссөн байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.


Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2022 оны 01 сарын 24

Зах зээлийн эргэн тойронд

- Netflix компани 4 дүгээр улирлын тайлангаа олон нийтэд танилцууллаа. Тус тайлангийн ихэнх үзүүлэлт шинжээчдийн таамаглалыг эвдсэн ч хувьцааны ханш 20 хувиар уналаа. Компанийн шинэ харилцагчдын тоо 4 дүгээр улиралд 8.28 саяд хүрсэн ч 2020 оны мөн үе дэх 8.5 саяыг гүйцсэнгүй. Netflix компани АНУ болон Канадад үйлчилгээний үнээ нэмэхээ зарласан, тус салбар дахь өрсөлдөөн ширүүсэж хэрэглэгчдийн өсөлт удаашрах болсонтой холбоотой гэж шинжээчид үзэж байна.
- 1995 оноос хойш Наздак индекс оройн цэгээсээ 10 болон түүнээс дээш буюу нийт 16 удаа уналт хийсэн бол цар тахлын нөлөөгөөр 2020 оны 2 сарын хойш 4 удаа засварын хөдөлгөөн хийгээд байна. Лхагва гарагт АНУ-ын Наздак индекс 11 сард хүрсэн бүх цагийн үеийн түүхэн дээд ханшаасаа 11 хувийн уналт үзүүлээд байгаа нь сүүлийн 2 жилийн хугацаанд технологийн салбарын индексийг донсолгосон 4 дэх засварын хөдөлгөөн болсон юм.

График : NASDAQ индексийн өгөөж



- Хөрөнгө оруулагчид Холбооны Нөөцийн Сан инфляцийг хяналтандаа авахын тулд бодлогын хүүгээ эрчимтэй өсгөнө гэж таамаглаж байна. Бодлогын хүүгийн өсөлт нь HIGH GROWTH төрлийн хувьцаанд муугаар нөлөөлдөг тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн компаниудыг ирээдүйд олох орлогоор нь үнэлдэг. Мөн хүүгийн өндөр түвшин нь ойрын орлогоос илүү ирээдүйн орлогыг багасгадаг.
- Одоогоор АНУ-ын Эрчим хүчний яам Ерөнхийлөгч Байдены зөвшөөрсний дагуу 7 сая гаруй баррель түүхий нефтийг компаниудад нийлүүлээд байна. Япон улс 2 сард үндэсний нөөцөөсөө 629 мянган баррель түүхий нефтийг дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөж байгаа бол БНСУ 2022 оны эхний улиралд 3.17 сая баррель газрын тосны нөөцийг гаргахаар байна. БНХАУ-ын хувьд нефтийн үнийг бууруулахын тулд цагаан сарын баяраар стратегийн нөөцөөсөө түүхий нефть гаргахаар АНУ-тай тохиролцсон байж магадгүй хэмээн зарим эх сурвалжууд дурьдсан байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

2022 оны 01 сарын 24

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning January 17, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
HDFC BANK		Goldman Sachs	Progress	Bank of America	Alcoa	American Airlines Group	NETFLIX	Schlumberger	
		charles SCHWAB	J.B. HUNT	Morgan Stanley	UNITED	Baker Hughes	INTUITIVE SURGICAL	ally	
		Silvergate	CONCENTRIX	ASML	kindredreogen.com	TRAVELERS	[CSX]	Huntington	
		PNC	Interactive Brokers	UnitedHealth Group	DISCOVER FINANCIAL SERVICES	KeyBank	SVB Financial Group	IHS Markit	
		BNY MELLON		P&G	H.B. Fuller	7th Third Bancorp	PPG	First Hawaiian Bank	
		TRUIST	United Community Banks	FASTENAL	WINTRUST FINANCIAL CORPORATION	REGIONS	Bank OZK		
		Monetta	Pinnacle Financial Partners	us bancorp	STERLING BANCORP	SYNOVUS	Limelight Networks		
		Signature Bank	Fulton Financial Corporation	PROLOGIS	ENB Corporation	Northern Trust	Metropolitan Bank Holding		
		First Midwest Bancorp. Inc.		STATE STREET	Comerica	M&T Bank			
http://eps.sh/cal						© 2022 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning January 24, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
HALLIBURTON	IBM	Johansen-Johnson	Microsoft	BOEING	TESLA	Mastercard	Apple	Chevron	
Bank of Hawaii	Steel Dynamics, Inc.	GE	TEXAS INSTRUMENTS	at&t	intel	NUCOR	Robinhood	CATERPILLAR	
Bank of Marin	CRANE	verizon	NETWORKS	Freemore McMillan COPPER & GOLD	Levi's	McDonald's	VISA	66	
COMMUNITY BANK SYSTEM, INC.	Boyet & Boyett	AMERICAN EXPRESS	Capital One	Abbott	Lam Research	Valero	Uss	COLGATE-PALMOLIVE	
sify	1-800-PetMeds	3M	MARTEN	Nasdaq	service now	The Blackstone Group	jetBlue	Weyerhaeuser	
ZIONS BANCORPORATION	Nextera Energy	Raytheon Technologies	NAVIENT	Anthem	SEAGATE	WD Western Digital	DOW	VI	
Smart Financial, Inc.	ADM	ADM	HAWAIIAN BIRLINES	PROGRESSIVE	LendingClub	Altria	BOOT BARN	synchrony	
Enterprise Financial	UMC	Agilysys		Kimberly-Clark	Sands Las Vegas Sands Corp.	SOUTHWEST	KLA	Badger Meter	
http://eps.sh/cal						© 2022 Earnings Whispers			

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.